



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ №8

НЭГ. Шувууны томуугийн А хүрээний вирусн шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:

2020 оны 4 дүгээр сарын 27-ноос 5- дугаар сарын 11-ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус АНУ, Унгар, Итали, Ирланд, Вьетнам зэрэг улс орны шувууны аж ахуйд илрээд байна. АНУ -д 1 удаагийн өвчлөл бүртгэгдэж 34160, Унгар улсад 4 удаа өвчлөл бүртгэгдэж 32130, Итали улсад 1 удаагийн өвчлөл бүртгэгдэж 7150, Ирланд улсад 1 удаагийн өвчлөл бүртгэгдэж 50000, Вьетнам улсад 5 удаагийн өвчлөл бүртгэгдэж 24208 тэжээмэл шувууд өртсөн байна (хүснэгт 1, зураг 1).

АНУ-д цацагт хяруулын аж ахуйд гарсан өвчлөл нь эхэндээ бага хоруу чанартай байсан ба сүүлд бүртгэгдсэн өмнөд Каролинд гарсан дэгдэлт илүү хоруу чанартай байсан байна. Генетик дарааллыг тогтоох судалгаагаар Н7 вирус нь бусад фермерт гарсан дэгдэлтээс ялгаатай байв. Гэвч зэрлэг шувууны дунд бүртгэгдсэн Н7 вирусн өвчлөлтэй гемагглютинин уургаар ижил байсан байна.

ХОЁР. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 4 дүгээр сарын 27-ноос 5- дугаар сарын 11-ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй.

ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

Мөн хугацаанд шувууны томуугийн А хүрээний H5N6 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн тохиолдол шинээр бүртгэгдээгүй.

ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 4 дүгээр сарын 27-ноос 5- дугаар сарын 11-ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 2 дугаар сарын 28-наас хойш шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусн хүний өвчлөлийн 2 тохиолдол БНХАУ-д бүртгэгдсэн байна. Сүүлийн тохиолдол нь Хунан аймгийн 5 настай охин байсан ба 4-р сарын 20 ноос өвчний шинж тэмдэг илэрч 4 дүгээр сарын 25-нд эмнэлэгт тусгаарлагдсан. Түүний эцэг эх нь шувууны худалдааны захаас шувуу худалдаж авч байсан байна. 2015 оноос хойш БНХАУ-д хүний өвчлөлийн 31 тохиолдол бүртгэгдсэн ба цаашид Африкт өсөх хандлагатай байна.

ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2020 оны 4 дүгээр сарын 27-ноос 5- дугаар сарын 11-ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй.


ДОЛОО. 2020 оны 4 дүгээр сарын 27-ноос 5 дугаар сарын 11-ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн шувууны мэдээлэл:

(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирусийн тархалт болон вирусийн хэлбэр

№	Шувууд өвчилж эхэлсэн өдөр	Хэлбэр	Улс	Муж	Өртсөн нийт шувуудын тоо	Аж ахуйн хэлбэр
1	6/4/2020	H7N3	АНУ	Өмнөд Каролин	34160	Цацагт хяруул
2	26/04/2020	H5N8	Унгар	Бэкеш	10760	Цацагт хяруул
3	27/04/2020	H5N8	Унгар	Бэкеш	9872	Галуу
4	27/04/2020	H5N8	Унгар	Бэкеш	11138	Тахиа
5	28/4/2020	H7N1	Итали	Тревизо	7,150	Цацагт хяруул
6	28/4/2020	H6N1	Умард Ирланд	Монахан	500,000	Тахиа
7	3/5/2020	H5N8	Унгар	Бэкеш	360	Тахиа
8	6/5/2020	H5N6	Вьетнам	Нэн Бэн	5833	Тахиа
9	6/5/2020	H5N6	Вьетнам	Ханой	15305	Тахиа
10	17/04/2020	H5N1	Вьетнам	Кантхо	1970	Тахиа
11	23/04/2020	H5N1	Вьетнам	Донгтхáp	300	Тахиа
12	27/04/2020	H5N1	Вьетнам	Виньлонг	800	Тахиа

Эх сурвалж: *Oie.int, Poultrymed.com, Cidrap.umn.edu*

(Зураг 1) Шувууны томуугийн А хүрээний вирус тархалт /зургаар/



ДОЛОО. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдолын мэдээлэл:

2020 оны 4 дүгээр сарын 27-ноос 5 дугаар сарын 11-ны хооронд шувууны томуугийн сэжигтэй буюу шувууд олноор үхсэн дуудлага бүртгэгдээгүй байна.

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Шувууны томуу хариуцсан баг